



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Бүгд Найрамдах Солонгос Улсын Самсунг эрүүл мэндийн төв хооронд 2015 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамжийн бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэжлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080443



Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 03 сарын 23-ны өдрийн  
А/88... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| №  | Овог нэр                     | Харьяалал                         | Ажиллах байгууллага                           | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэжлийн чиглэл             | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа          |
|----|------------------------------|-----------------------------------|---|--------------------------|---|-------------------|---------------------------------------|
| 1. | Жон Тэ Гук<br>Jun Tae Gook   | Бүгд<br>Найрамдах<br>Солонгос Улс | Эх, хүүхдийн<br>эрүүл мэндийн<br>үндэсний төв | ГЭ0001880                | Хүүхдийн<br>зүрхний мэс<br>засал судлал | Эмчлэх            | 2018-03-25<br>2018-03-30<br>/6 хоног/ |
| 2. | Со Чон Мин<br>Seo Jeong Meen | Бүгд<br>Найрамдах<br>Солонгос Улс | Эх, хүүхдийн<br>эрүүл мэндийн<br>үндэсний төв | ГЭ0001881                | Хүүхдийн мэс<br>засал судлал            | Эмчлэх            | 2018-03-25<br>2018-03-30<br>/6 хоног/ |